

Журмын 4 дүгээр хавсралт.  
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, хүлээж авах загвар

б. Уул уурхайн олборлолт, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хуудас

1. Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: Дацан трейд ХХК-ны 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт
2. Төслийн байршил: Хэнтий аймаг Норовлин сум
3. Регистрийн дугаар: 2061848
4. Огноо: 2022.11.22

| № | Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг   | Авбал зохих оноо | Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо |         |               |             |               |           |               | Ж.Эрдэнатуяа | Гишүүдийн үнэлсэн онооны дундаж | тайлбар   |
|---|--|------------------|--------------------------------------|---------|---------------|-------------|---------------|-----------|---------------|--------------|---------------------------------|---|
|   |  |                  | Б.Дарахнтөр                          | Д.Шараа | Г.Мөнх-Эрдэнэ | Т.Баатарсүх | А.Мөнхбайгаль | Г.Мөнхзул | М.Түмэнжаргал |              |                                 |   |
| 0 | 1  | 2                | 3                                    | 4       | 5             | 6           | 7             | 8         | 9             | 10           | 11                              | 12  |
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт  | 20               | 20                                   | 20      | 20            | 20          | 20            | 20        | 20            | 20           | 20                              | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд 16 ажил төлөвлөснөөс ажил 16 ажил гүйцэтгэсэн.                             |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт, татан буулгах, хаалтад бэлтгэх/ | 30               | 22                                   | 22      | 22            | 22          | 21            | 22        | 22            | 22           | 21.9                            | Техникийн нөхөн сэргээлт 2.8 га төлөвлөснөөс 1.4 га, биологийн нөхөн сэргээлт 5.5 га талбайд 5.4 га талбайд хийсэн. |
| 3 | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт  | 10               | 10                                   | 10      | 10            | 10          | 10            | 8         | 10            | 10           | 9,7                             | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд 2 ажил төлөвлөснөөс 2 ажил гүйцэтгэсэн.   |

|      |   |     |    |    |    |    |    |    |    |    |     |  |
|------|---|-----|----|----|----|----|----|----|----|----|-----|--|
| 4    | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт   | 5   | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5   | Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнд 2 ажил төлөвлөснөөс 2 ажил гүйцэтгэсэн.                |
| 5    | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт   | 5   | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5   | Уурхайн олборлолтын үед түүх соёлын дурсгал илрээгүй.                                  |
| 6    | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт  | 10  | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10  | Осол эрсдлийн менежментийн хүрээнд 2 ажил төлөвлөснөөс 2 ажил гүйцэтгэсэн.             |
| 7    | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт  | 5   | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5   | хог хаягдлын менежментийн хүрээнд 3 ажил төлөвлөснөөс 3 ажил гүйцэтгэсэн               |
| 8    | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт   | 5   | 5  | 5  | 5  | 5  | 5  | 4  | 5  | 5  | 4.9 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 4 ажил төлөвлөснөөс 3 ажил хэрэгжүүлсэн. |
| 9    | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт   | 5   | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5  | 5   | Удирдлага зохион байгуулалтын хүрээнд 2 ажил төлөвлөснөөс 2 ажил хэрэгжүүлсэн.         |
| 10   | Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт | 5   | 5  | 5  | 5  | 4  | 5  | 4  | 5  | 5  | 4.7 | Олон нийтэд тайлагнах хуваарийн хүрээнд 4 ажил төлөвлөснөөс 3 ажил хэрэгжүүлсэн.       |
| Нийт |   | 100 |    |    |    |    |    |    |    |    |     | 91,2   |

Тайлбар: Бүрэлдэхүүн хэсэг тус бүрт биелэлтээс нь хамааран авсан байвал зохих оноог тогтоосон ба ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн онооны энгийн арифметик дунджийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тооцож гаргана. Гишүүдийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт өгсөн онооны энгийн арифметик дунджийн нийлбэр нь нийт оноо болно. Тухайн жилийн байгаль

орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн биелэлтийн нийт оноо нь 90-аас доош байвал төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй гэж үзнэ. Тухайн жилд дүйцүүлэн хамгаалах ажил төлөвлөгдөөгүй бол нөхөн сэргээх арга хэмжээ рүү, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй бол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт рүү шилжүүлж тооцно

Дүгнэлт:


Тус байгууллагын 2022 оны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт 91.2 хувьтай хийгдсэн тул хангалттай сайн гэж үзэж байна. Дараа жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын А-618 тушаалаар батлагдсан журмын дагуу хийж гүйцэтгэх. Мөн менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн ажлыг үнэлэх боломжтой, хэмжигдэхүйц, хугацаа, зардлыг тодорхой төлөвлөх шаардлагатай. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төлөвлөхдөө "Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ"-ний төлөвлөгөөнд 2.5 гектараас багагүй талбайд хийж гүйцэтгэхээр тусгах.

Ажлын хэсгийн ахлагч  
Байгаль орчин, Аялал жуулчлалын  
газрын дарга



Б.Дархантөр

Гишүүд:  
Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын  
Геологи, уул уурхайн хяналтын улсын  
ахлах байцаагч




Д.Шараа

Байгаль орчин аялал жуулчлалын газрын  
мэргэжилтэн




Г.Мөнх-Эрдэнэ

Хэрлэн голын  
сав газрын Ахлах мэргэжилтэн



Т.Баатарсүх

Сумын Засаг дарга



А.Мөнхбайгаль

Сумын Байгаль Орчны хяналтын Улсын байцаагч



Г.Мөнхзул

Сумын газрын даамал




М.Түмэнжаргал

Баян-Өлзийт Багийн Засаг дарга




Ж. Эрдэнэтуяа

Хүлээн зөвшөөрсөн:



"Дацан трейд" ХХК-ны захирал



Э.Батсайхан

**ДАЦАН ТРЕЙД ХХК-ЫН 2022 ОНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТ  
ХҮЛЭЭЖ АВАХ АКТ**

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 03

| № | Асуулт  | Хариулт  |
|---|---|--|
| 1 | Байршил Аймаг ,нийслэл: сум,<br>дүүрэг: баг, хороо: газрыннэр:  | Хэнтий аймаг Норовлин сум, Салхитын алтын шороон орд   |
| 2 | Аж ахуйн нэгжийн нэр<br>Хаяг: Аж ахуйн нэгжийн<br>гэрчилгээний дугаар: регистр:                           | “ Дацан трейд” ХХК Улаанбаатар хот,<br>Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын<br>гудамж, өөрийн байранд 3-Б хэсэг |
| 3 | Тусгай зөвшөөрлийн дугаар:<br>Талбай:   | MV-015599  |
| 4 | Нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн<br>албан тушаалтан: овог нэр:  | “ Дацан трейд” ХХК-ын гүйцэтгэх захиарал<br>Э.Батсайхан  |
| 5 | Нөхөн сэргээлтийн ажлыг газар<br>дээр нь хэмжиж зураглал<br>үйлдсэн мэргэжлийн<br>байгууллагын нэр: хаяг: | “Оюу Survey” ХХК   |
| 6 | <b>Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, чанар, үр дүн:</b>   |  |
| 7 | Ирэх онд хийх нөхөн сэргээлтийн<br>хэмжээ /Га-аар/  |  |

Тус компани нь MV-015599 тусгай зөвшөөрлийн дугаартай Баян Уулын алтны шороон ордод үйл ажиллагаа явуулдаг Дацан трейд ХХК нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

**Нөхөн сэргээлт:**


2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөснөөс 1.4 га талбайд, биологийн нөхөн сэргээлт 5.5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөснөөс 5.4 га талбайд MNS5916:2008, стандарт техникийн шаардлагыг мөрдөн 74% хийж гүйцэтгэсэн байна.

**Дүгнэлт:**

Тус байгууллагын 2022 оны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт 74 хувьтай хийгдсэн тул ажлын хэсэг санал нэгтгэйгээр хүлээн авч, акт үйлдэхээр шийдвэрлэлээ. 2023 оны менежментийн төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийн 1.4 га талбай, 0.3 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил тодотголоор нэмж тусгах шаардлагтай.

АКТ ГАРГАГАН:

Ажлын хэсгийн ахлагч  
Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын дарга



Б.Дархантөр


Гишүүд:

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын  
Геологи, уул уурхайн хяналтын улсын  
ахлах байцаагч



Д.Шараа

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
Мэргэжилтэн



Г.Мөнх-Эрдэнэ

Хэрлэн голын сав газрын захиргааны  
Мэргэжилтэн



Т.Баатарсүх

Норовлин сумын Засаг дарга



А.Мөнхбайгаль

Сумын Байгаль орчны хяналтын  
Улсын байцаагч




Г.Мөнхзул

Газрын даамал




М.Түмэнжаргал

Баян-Өлзийт багийн Засаг дарга




Ж.Эрдэнэтуяа

Хүлээн зөвшөөрсөн:



"Дацан трейд" ХХК-ны гүйцэтгэх захирал




Э.Батсайхан



Теникийн нөхөн сэргээлтийн эргэлтийн цэг

| id | deg_X | min_X | sec_X | deg_Y | min_Y | sec_Y | Талбай /га/ | X        | Y        |
|----|-------|-------|-------|-------|-------|-------|-------------|----------|----------|
| 1  | 112   | 16    | 47.83 | 48    | 19    | 43    | 1.4         | 112.28   | 48.32861 |
| 2  | 112   | 16    | 45.95 | 48    | 19    | 44.1  |             | 112.2794 | 48.32892 |
| 3  | 112   | 16    | 48.1  | 48    | 19    | 45.65 |             | 112.2795 | 48.32935 |
| 4  | 112   | 16    | 53.45 | 48    | 19    | 47.81 |             | 112.2815 | 48.32995 |
| 5  | 112   | 16    | 56.12 | 48    | 19    | 45.56 |             | 112.2823 | 48.32932 |



**Биологийн нөхөн сэргээлтийн эргэлтийн цэг**

| id | deg_X | min_X | sec_X | deg_Y | min_Y | sec_Y | Талбай /га/ | X        | Y        |
|----|-------|-------|-------|-------|-------|-------|-------------|----------|----------|
| 1  | 112   | 14    | 58.2  | 48    | 21    | 26.86 | 0.2         | 112.2495 | 48.35746 |
| 2  | 112   | 14    | 59.68 | 48    | 21    | 27.71 |             | 112.2499 | 48.3577  |
| 3  | 112   | 15    | 3.1   | 48    | 21    | 26.04 |             | 112.2509 | 48.35723 |
| 4  | 112   | 15    | 2.27  | 48    | 21    | 25.51 |             | 112.2506 | 48.35709 |
| 1  | 112   | 16    | 50.08 | 48    | 19    | 37.18 | 3.7         | 112.2806 | 48.32699 |
| 2  | 112   | 16    | 45.02 | 48    | 19    | 40.68 |             | 112.2792 | 48.32797 |
| 3  | 112   | 16    | 40.54 | 48    | 19    | 44.9  |             | 112.2779 | 48.32914 |
| 4  | 112   | 16    | 35.18 | 48    | 19    | 49.94 |             | 112.2764 | 48.33054 |
| 5  | 112   | 16    | 38.15 | 48    | 19    | 51.33 |             | 112.2773 | 48.33093 |
| 6  | 112   | 16    | 43    | 48    | 19    | 45.86 |             | 112.2786 | 48.32941 |
| 7  | 112   | 16    | 51.09 | 48    | 19    | 41.07 |             | 112.2809 | 48.32808 |
| 8  | 112   | 16    | 52.22 | 48    | 19    | 37.8  |             | 112.2812 | 48.32717 |
| 1  | 112   | 16    | 51.88 | 48    | 19    | 41.4  | 1.5         | 112.2811 | 48.32817 |
| 2  | 112   | 16    | 55.19 | 48    | 19    | 42.24 |             | 112.282  | 48.3284  |
| 3  | 112   | 16    | 57.73 | 48    | 19    | 36.31 |             | 112.2827 | 48.32675 |
| 4  | 112   | 16    | 53.72 | 48    | 19    | 35.22 |             | 112.2816 | 48.32645 |

*АГУУЛГА*

|   |                                     |
|---|-------------------------------------|
| <i>ОРШИЛ</i> .....  | 2                                   |
| Уул технологийн хэсэг.....  | 5                                   |
| Уурхайн жилийн хүчин чадал, ашиглах хугацаа.....  | 5                                   |
| Уурхайн ажиллах горим.....  | 6                                   |
| Ил уурхайн үндсэн хэмжээсүүд.....   | <b>Error! Bookmark not defined.</b> |
| Уулын үндсэн техникүүдийн хүчин чадал, хэрэгцээний тооцоо.....                                    | <b>Error! Bookmark not defined.</b> |
| Ашиглалтын систем.....  | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 2022 онд гүйцэтгэсэн уулын ажлын хэмжээ.....  | 7                                   |
| <i>ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ СУДАЛГАА</i> .....   | 7                                   |
| Талбайн геологийн тогтоц.....   | <b>Error! Bookmark not defined.</b> |
| Ус зүй:.....  | 8                                   |
| Хөрсөн бүрхэвч.....   | 8                                   |
| Ургамлан нөмрөг.....  | 8                                   |
| Амьтны аймаг.....   | 9                                   |
| <i>ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ<br/>ТОДОРХОЙЛОЛТ</i> .....               | 10                                  |
| <i>ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН<br/>ЗОРИЛГО</i> .....               | 10                                  |
| Эрх зүйн үндэслэл.....  | 11                                  |
| <i>ТАВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i> .....   | 12                                  |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөө.....  | 12                                  |
| Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....   | 12                                  |
| 5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....                         | 13                                  |
| 5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....   | 16                                  |
| 5.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт.....                    | 19                                  |
| 5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....             | 18                                  |
| 5.5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт.....                                      | 21                                  |
| 5.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....                                       | 19                                  |
| 5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....   | 22                                  |
| 5.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн биелэлт (охшх).....                                   | 23                                  |
| 5.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....                                     | 25                                  |
| 5.10. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнаж, хэлэлцүүлэх хуваарь:..... | 26                                  |
| 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үед олон нийтийн оролцоог хангасан нь.....  | 27                                  |



## ОРШИЛ

“Дацан трейд”ХХК-нь 1996 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд уул уурхайн салбарт тогтмол үйл ажиллагаа явуулсаар ирлээ. Манай компаний Баян-Уулын алтны шороон орд нь Хэнтий аймгийн Норовлин сумын нутгийн зүүн урд хэсэгт сумын төвөөс 50 км-т оршино. Уг ордод "Дацантрейд" ХХК 2005-2009 оны хайгуулын ажлын үр дүнгээр нөөц бодож 2010 оны 02 -р сарын 26 –ны өдөр ЭБМЗ –ийн хурлаар алтны бодит В зэргээр 67,25 кг, боломжит С зэргээр 395,16 кг, бүгд 456,69 кг \химийн цэврээр\ нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд авсан болно.

Мөн 2011 онд гүйцээх хайгуул хийж ордын нөөцийн зэргийг өсгөсөн ба 2011 оны 12-р сарын 16-ны өдөр ЭБМЗ-ийн хурлаар алтны бодит В зэргээр 389,18 кг/ химийн цэврээр/ нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд авсан болно.

2022 онд MV-015597, 015599 тоот тусгай зөвшөөрөл бүхий Уртын хөндийн ордын хөндөгдсөн газраас 1,4 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 5.5 га талбайд олон наст ургамал болох царгас, согооврын үр тарьж биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэн сум, орон нутагт чанарын сайн дүнтэйгээр (91.2%)хүлээлгэн өгөв.

Уг уурхай нь 2022 оны 05 -р сарын 1 -наас 05 -р сарын 05-ийг хүртлэх хугацаанд уул техникийн бэлтгэл ажлыг үндсэндээ дуусгаад, 05 -р сарын 05–наас хөрс хуулалт, 5-р сарын 10 -с элс таталт хийж, 5-р сарын 12-с 10-р сарын 10 хүртэл олборлолтын үйл ажиллагаа явуулж, 10-р сарын 11-аас 10-р сарын 30-ыг хүртэлх хугацаанд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 7-р сарын эхээр биологийн болон шимт хөрсний нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн.

1. Хөрс хуулалт- хадгалалт- гадаад овоолго-хөрс зөөвөр-элс гаргалт, зөөлт-баяжуулалт-дотоод овоолго-дүүргэлт-тэгшлэлт-техникийн нөхөн сэргээлт- шимт хөрсөөр хучилт-биологийн нөхөн сэргээлт гэсэн дараалалтай ажилласан.
2. Төхөөрөмжийн ачаалах бункерт экскаватороор баяжуулах материалыг жигд асгаж өгнө. Бункерт орсон материал усаар өөрөө туугдан төхөөрөмжийн задлах хэсэгт орохдоо самрагчаар өргөгдөн шидэгдэж, саатуулах босгонд тулж устай баяжмал тогтмол түвшинд жигд задаргаа явагдан улмаар шигшин ялгах давхар хүрдэнд /барабанд/ дамжин орж 0 - 22, 22 - 36 36 мм-ээс дээш гэсэн гурван төрлөөр ангилагдан шигшигдэж нам, гүн дүүргэлтийн тунгаагуур, хаягдлын хоолой тус бүрт хувиарлагдан ялгагдсан.

Нам дүүргэлтийн шлюзэнд алтны баяжуулалт явагдахад баяжмалыг даралттай усны хольцоор тогтмол сийрэгжүүлсэнээр алтны барилт хамгийн ашигтай горимоор явагдана. Гүн дүүргэлтийн тунгаагуурт том ширхэглэлтэй алтыг ердийн горимоор суулгаж авдаг.

Нам дүүргэлтийн тунгаагуурыг өдөр тутам, гүн дүүргэлтийн тунгаагуурыг долоо хоногт нэг удаа тус тус хуулалт хийсэн. Төхөөрөмжийн хаягдалын хоолойгоор дамжин гарсан хаягдлыг олборлолтын үед үүссэн нүхэнд хийсэн.

Шлюзны коврик дээр алттай шлих үлдэж, эфель нь урсаж гарна. Гарсан баяжмалыг соронзонгоор ялгаж алтаа дагалдагч хүнд эрдсүүдээс салгана. Дагалдагч хүнд

эрдсүүдийг тусгай хаягдалд хуримтлуулан цуглуулж ордыг ашиглаж дууссаны дараа дахин эрдсийн шинжилгээ хийж ашиглах боломжтой.

3. Ш.Ч-IV маркийн алт угаах төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүд:


1. Гадна хүрдний /барабан/диаметр, мм - 1520  
нүхэлсэн хэсгийн урт.мм - 2000  
нүхний диаметр.мм - 22
2. Дотор хүрдний диаметр мм – 1220  
нүхэлсэн хэсгийн урт.мм - 2000  
нүхний диаметр.мм – 36
3. Хүчин чадал.м / цаг - 40 : 50
4. Эргэлтийн хурд, эр/мин - 18
5. Цахилгаан хөдөлгүүрийн чадал, кВт - 22
6. Төхөөрөмжийн овор хэмжээ, м урт - 6.0,  
өргөн - 2.5,  
өндөр - 3.3
7. Хүндийн жин, тн - 8.0

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

|  |  |
|--|--|
| <b>ТӨСЛИЙН ДУГААР:</b>                       | 2012/В478  |
| <b>ТӨСЛИЙН НЭР, АНГИЛАЛ:</b>                 | Хэнтий аймгийн Норовлин сумын нутаг Уртын хөндийн алтны шороон ордыг ашиглах                               |
| <b>ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН НЭР:</b>            | "Дацантрейд" ХХК   |
| <b>ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:</b>            | MV-015597, MV-015599   |
| <b>АЖ АХУЙН НЭГЖИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУГААР:</b> | 9011094114   |
| <b>РЕГИСТРИЙН ДУГААР:</b>                    | 2061848  |
| <b>ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ:</b>           | Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Өөрийн байранд - 3Б хэсэг, утас: 99026118, 326025 |
| <b>ТӨСЛИЙН БАЙРШИЛ</b>                       | Хэнтий аймгийн Норовлин сум  |

*Орд байрлах солбилцол*

| №         | Уртраг |     |       | Өргөрөг |     |       |
|-----------|--------|-----|-------|---------|-----|-------|
|           | град   | мин | сек   | град    | мин | сек   |
| MV-015599 |        |     |       |         |     |       |
| 1         | 112    | 16  | 21.79 | 48      | 20  | 23.71 |
| 2         | 112    | 16  | 21.86 | 48      | 20  | 10.24 |
| 3         | 112    | 16  | 42.13 | 48      | 20  | 10.28 |
| 4         | 112    | 16  | 42.12 | 48      | 20  | 22.33 |
| 5         | 112    | 16  | 58.02 | 48      | 20  | 22.34 |
| 6         | 112    | 16  | 58.02 | 48      | 19  | 46.84 |
| 7         | 112    | 17  | 23.02 | 48      | 19  | 46.83 |
| 8         | 112    | 17  | 23.02 | 48      | 19  | 18.83 |
| 9         | 112    | 16  | 47.02 | 48      | 19  | 18.83 |
| 10        | 112    | 16  | 47.02 | 48      | 19  | 37.84 |
| 11        | 112    | 16  | 21.02 | 48      | 19  | 37.84 |
| 12        | 112    | 16  | 21.02 | 48      | 19  | 57.84 |
| 13        | 112    | 15  | 36.02 | 48      | 19  | 57.84 |
| 14        | 112    | 15  | 36.02 | 48      | 20  | 14.84 |
| 15        | 112    | 16  | 2.02  | 48      | 20  | 14.84 |
| 16        | 112    | 16  | 2.02  | 48      | 20  | 31.84 |
| 17        | 112    | 16  | 58.02 | 48      | 20  | 31.84 |
| 18        | 112    | 16  | 58.02 | 48      | 20  | 23.8  |



Зураг: 1. Ордын байршил



Зураг: 2. Ашигт малтмал ашиглалтын талбайдын ерөнхий байдал

### Уул технологийн хэсэг

Ашиглалтын үеийн хөрс хуулалтын дундаж зузаан 2,6-3,4м, алт агуулагч элсний дундаж зузаан 1.5, хөрс хуулалтын дундаж коэффициент 2.0 байгаа нь уг орд нь бага гүнд оршиж байгаатай холбоотой бөгөөд олборлолт явуулахад уул техникийн хүндрэл гараагүй. Мөн ордын талбай нь гидрогеологийн хувьд мөн тааламжтай нөхцөлд оршдог тул ашиглалтын үеийн технологийн усан хангамжид хүндрэл гараагүй. Уртын хөндийн дунд, доод хэсэг нь усаар нэлээн элбэг бөгөөд 2,0 м-ээс доош байнга устай намагжсан байдалтай байна. Иймд ордыг ашиглах явцад үйлдвэрийн усан хангамжийг хөрсний усыг тунгаан эргэлтэнд оруулан ашиглах бүрэн боломжтой. Мөн ахуйн усан хангамжийг худагийн усаар хангадаг.

Уурхайн жилийн хүчин чадал, ашиглах хугаца

2022онд уулын ажлын төлөвлөгөөнд тусгаснаар 3-В, 4-В блокын хагасыг 5 сарын 01-ээс 10 сарын 03 хүртэл ашигласан бөгөөд ашиглалтын явцад 129 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 32,0 мян.м<sup>3</sup> элс угаасан.

Уурхайн ажиллах горим

Элс угаан баяжуулах ажил нь дулааны улиралд хийгдэх шаардлагатай тул элс олборлолтын ажлыг төслийн хугацаанд 5 дугаар сарын 01-аас 10 дугаар сарын 03 хүртэл хугацаанд явуулсан.

Ил уурхайн үндсэн хэмжээсүүд

Хөрс хуулалт болон элс олборлолтын ажилд буюу ил уурхайн ажиллах техник тоног төхөөрөмжөөс шалтгаалуулан ил уурхайн үндсэн хэмжигдэхүүнийг дараах байдлаар сонгосон.

*Уурхайн үндсэн хэмжигдэхүүнүүд*

| № | Хэмжигдэхүүнүүд         | Хэмжээ          |
|---|-------------------------|-----------------|
| 1 | Ажлын доголын өндөр     | 5.0м            |
| 2 | Ордын өргөн             | 7.0м            |
| 3 | Доголын налуугийн өнцөг | 55 <sup>0</sup> |
| 4 | Траншейн налуу          | 70%             |
| 5 | Ажлын талбайн өргөн     | 9.5м            |

Хөрс хуулалт

2022 онд Баян уулын уурхай нь 129,0 мян.м<sup>3</sup> хөрс хуулж стандартын дагуу овоолго үүсгэн хадгалсан.

Уулын үндсэн техникүүдийн хүчин чадал, хэрэгцээний тооцоо

Ордыг ашиглахад доорх техник хэрэгслэлийг ашиглах болно. Үүнд:

|                   |       |
|-------------------|-------|
| Бульдозер CAT D5  | - 1 ш |
| Бульдозер SD-23   | - 1 ш |
| Эксковатор SE-210 | - 1 ш |
| Эксковатор –3001  | - 1 ш |
| Скруббер СКР -50  | - 1 ш |
| Насос /хятад/     | - 1 ш |

Овоолгын аж ахуй

Үржил шимт хөрс буюу 0,3 м-ийн зузаан өнгөн хэсгийг уурхайн төвөөс 2 тийш бульдозероор түрж, уурхайн хилийн гадна талбайд далан маягаар овоолж байрлуулсан. Элс угаах ажилд скруббер хэрэглэх тул ашиглалтын явцад хөрсийг богино зайд тээвэрлэн, олборлолсон хоосон орон зайг дотоод овоолгоор дүүргэж, бульдозероор тэгшилж, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг зэрэг хийж гүйцэтгэсэн.

### Ашиглалтын систем

Ордын уул геологийн нөхцөл, одоо ашиглаж буй уурхайн тоног төхөөрөмж, тэдгээрийн хүчин чадал зэргийг харгалзан үзэж уурхайн өнөөгийн авто тээвэртэй, дотоод овоолго бүхий ашиглалтын системийг үргэлжлүүлэн ашиглах боломжтой гэж үзлээ.

Элс баяжуулах ажилд скруббшр ашигласнаар элс болон хөрсийг богино зайд тээвэрлэж, уурхайн ашигласан орон зайг дотоод овоолгоор дүүргэж, техникийн нөхөн сэргээлтийн ажлын нэгэн зэрэг хийх юм. Энэ нь уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг богино хугацаанд хийх нөхцлийг бүрдүүлж байна.

Уртын хөндийн ордын ашиглалтын үндсэн процессууд:

- Үржил шимт өнгөн хөрс хуулалтын ажил
- Хөрс хуулалтын ажил
- Элс олборлолтын ажил
- Элс угаалтын (баяжуулалтын) ажил
- Хөрсний овоолгын тэгшлэлийн ажил
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил

### 2022 онд гүйцэтгэсэн уулын ажлын хэмжээ

Энэхүү 2022 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өртсөн нийт талбай 3,7 га.

Мөн энэ онд уурхайн хэмжээнд 129,0 мян.м<sup>3</sup> хөрс хуулсан ба үүнээс 12900м<sup>3</sup> нь шимт хөрс болно.

Уурхайн үйл ажиллагаанд өртсөн талбайн шимт хөрсийг 0.2-0.4м-ын зузаантайгаар хуулж, Монгол Улсын MNS 5917:2008 зааврын дагуу олборлолтын дараах нөхөн сэргээлт хийхэд өнгөн бүрхүүлийг хучих материал болгон ашиглахад зориулан хөрсний овоолгоос тусад нь тусгайлан байршуулсан.

2022 онд нийт 129,0 мян.м<sup>3</sup> хөрс хуулсан бөгөөд үүний 30%-ийг өмнө ухсан хоосон орон зайд, 50%-ийг дотоод овоолгод байршуулсан.

## **ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ СУДАЛГАА**

### Хэнтий аймгийн уур амьсгалын өөрчлөлт

Хэнтий аймгийн нутаг эх газрын уур амьсгалын их мужид багтах бөгөөд эх газрын эрс тэс уур амьсгалтай. Уур амьсгал нь адил өргөрөгт орших бусад нутгаас нилээд онцлогтой. Байгалийн бүс, бүслүүрийн хувьд олон бүсэд хамаарагддаг. Тиймээс уур амьсгалын өөрчлөлт бүс бүрд өөр өөр давтамж, хэмжээгээр илэрдэг төдийгүй үзүүлэх нөлөөлөл нь янз бүр байдаг. Иймээс тухайн орон нутаг бүр уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицаж амьдарч сурахын тулд өөрчлөгдөж буй хүчин зүйлсийн учир шалтгааныг мэдэж байх нь туйлын чухал юм.

### Талбайн геологийн тогтоц

Судалгааны талбайд 1:200 000 масштабтай эрэл зураглалын ажил хийгдсэн ба геологийн тогтоцын хувьд нийлмэл бөгөөд Хэнтийн салбар уулсын зүүн хэсгээр байрладаг. Монгол Өвөр байгалийн структур-формацийн бүс, Төв Монголын атираат системд хамаарагдана. Тус талбайд палезойгоос эхлээд Дөрөвдөгч хүртэл янз бүрийн

насны, янз бүрийн найрлагатай тунамал, вулканоген, интрузив чулуулгууд тархсан маш нийлмэл геологийн тогтоцтой.

Талбайн хэмжээнд тархсан чулуулгуудын найрлага хувирлын зэрэг, хоорондын харьцаа, амьтан ургамлын үлдэгдлийг харгалзан дараахь давхарга зүйн ангиллыг хийсэн байна. Уг талбайн хурдас чулуулгууд нэлээд сайн судлагдаж ангилагдсан байна.

#### Ус зүй:

Судалгааны талбай дотор урсаж байгаа голууд байхгүй бөгөөд урсдаггүй голын хөндийнүүд байна. Эдгээр нь ихэнхдээ V хэлбэртэй бөгөөд эх рүүгээ нарийхан, адаг руугаа өргөссөн байх бөгөөд уулнаасаа эх авна. Судалгааны талбайд цэнгэг, усны устай нэлээд хэдэн булаг, худаг байдаг. Үүнд: Өгөөмөрийн худаг, Уртын булаг, Өлзийт булаг зэрэг юм.

#### Хөрсөн бүрхэвч

Энэ нутаг нь хөрс-газарзүйн мужлалтаар Хангайн мужийн өндрийн бүсшилийн Хангай-Хэнтийн дэд мужийн 54-р тойрогт багтана.

Уулын хоорондох хөндий, уул толгодын налуу хажууд хар хүрэн хөрс голлохын хамт ам хөндийн ёроолд нь нугат-хүрэн, нугат-хар шороон, нугат-намгийн хөрстэй байна.

Хөрс ихэнхидээ хөнгөн элсэнцэр бүрэлдэхүүнтэй байгаа нь эвдрэлд хялбархан нэрвэгдэж, үржил шимээ түргэн алдах нөхцөлтэй.

Энэ тойрог хээрийн бүсийн бусад нутагтай харьцуулахад илүү чийглэг шинжтэй, хур тундас арай илүүтэй унадаг учир ургамлын ургац харьцангуй сайн өтгөн, өндөр ургасан байна.

Ургамлан бүрхэвчид алаг өвс-үетэн-агьт хээр зонхилж хялгана, биелэг өвс ихтэй, агь, дааган сүүл, хазаар өвс бүхий ургамлын бүрхэц 60-70% хүрнэ.

Хөрсний хими-физик шинж: Ашиглалтын талбайн хөрсөнд хийсэн задлан шинжилгээний дүнгээс харахад ашиглалтын талбайн хэмжээнд тархсан хөрс нь хөрс үүсгэгч эх чулуулгийн төрөл, тэдгээрийн илрэх гүн, ул хөрсний усны тэжээлийн нөхцлөөс хамаарч харилцан адилгүй шинж чанартай байна. Тухайлвал хөрсний дээд А давхаргад ялзмагийн хэмжээ ялзмаг ихтэй хар шороон хөрсөнд 8,71%, нугат-намгийн бүдүүн ялзмагт глейт хөрсөнд 15,05% задарч амжаагүй органик бодис ихтэй, далд глейрхэг хар шорон хөрсөнд 7,44%, ердийн хар хөрсөнд 3,52-3,69% -д хэлбэлзэж харилцан адилгүй хэмжээтэй байна.

#### Ургамлан нөмрөг

Норовлин сум ойт хээр, хээрийн бүсэд байрладаг бөгөөд 533.3 мянган гектор нутагтай, нутгийн умард цэг Онон голоос өмнөд цэг Шилийн холбоо хүртэл 120км, өрнөд цэг Цогт-Өндөрөөс /дэлгэр булгийн давааны/ дорнод цэг бага Онцгой уулын орой хүртэл 70 орчим км, хойноос өмнө зүгт сунасан өргөн уудам нутагтай. Бүх нутгийн ихэнх хэсгийг ойт хээр, бусдыг нь тал хээр, ухаа гүвээ толгод эзэлдэг.

Нийт нутгийн өндөр цэг сумын төвөөс баруун өмнө 35 км орчимд буй Хаядэлгэр хаан уул 1594.3м, хойно орших Бүрэн хаан уул 1554.0м, зүүн урд байрлах Түмэн хаан уул 1357.0м, Норовлин Баян уул сумын заагт орших Дун хаан уул 1534.7м

болон хойт хэсэгтээ Хэнтийн нурууны салбар уулс болох Эрээн давааны нурууны зэрэг ой модот уулстай.

Сумын хамгийн нам дор газар нь сумын төвөөс зүүн тийш 30 км -т Улзын голын дагуу 950 м орчим өргөгджээ .Сумын нутаг нь далайн төвшингөөс дунджаар 1200 м өргөгдсөн, Нутаг дэвсгэрт жилдээ 220-230 мм орчим тунадас унаж, хөрсний 60 орчим хувь нь борооны, 40 орчим хувь цасны чийгээр тэжээгддэг учир ган зуд тохиох нь харьцангуй цөөн.

Хүйтний дээд хэмжээ нь 39 хэм гаруй, дулааны дээд хэмжээний 37хэмээс төдийлөн хэтэрдэггүй. Салхины чиглэл голдуу баруун хойноосоо, өвлийн улиралд баруун өмнөдөөс голлодог. Хамгийн их салхи хавсаргатай үе 3,4,5-р сар үе үе 14-20м/сек хүрч ширүүсдэг боловч ихэнхдээ тогтуун нарлаг байдаг. Уулын чулуулаг, намгархаг, хээрийн шороон хөрсний давхаргатай, уул даваа олонтой .Шивэрийн даваа, Улаанхамар, Их даваа, Сонор, Цагаан даваа, Ар ,Өвөр Орной, Хуцын хоолой, Уртын хөндий, Хулстай, Хонгор, Ангиртын тал гэх мэт олон тал хөндийтэй.

Онон, Улз, Орной Хөндий, Дарцагт, Урт ,Бэрх Баянгол, Могой Мэхээрч, Хуцын Гол, Алтан эмээл, Цагаан чулууут, Шивэр, Хөндлөн,Баянбулаг, Замт зэрэг гол мөрөн горхинуудтай боловч ихэнх нь ширгэж байна.

Мөн Улзын Цагаан нуур, Түмэнхааны Цагаан нуур,Хулстай, Ангирт Бул нуур далтын Цагаан нуур, Улзын Хулстай, Харчулуут, Хар нуур, Цэгээний нуур гэх мэтийн олон нууруудтай боловч зарим нь ширгэж байгаа нь байгаль экологийн тэнцвэр алдагдаж байгааг харуулж байна. Тогоот, Замт, Улаалзаргана зэрэг рашаан булаг шандтай. Шилмүүст навчит ойтой. Үүнд шинэс, нарс, хус, улиас, бургас зэрэг модтой бэлчээрийн төрөл бүрийн ургамалтай.

#### Амьтны аймаг

Хэнтий аймгийн норовлин сумын нутагт орших Уртын хөндийн орд газар нь амьтны газарзүйн мужлалын хувьд Хэнтийн тойрогт тойрогт багтана. (А.Г.Банников, 1954)

Нийт талбайд тарвага, чандага, туулай, үнэг, хярс, дорго, чоно, гөрөөс, мэрэгчид ба махчин амьтад амьдардаг. Жигүүртнээс шаазгай, хар хэрээ, цахлай болон бусад төрлийн шувууд байдаг.



## ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү төслийн БОНБНҮнэлгээний тайлангаас үзэхэд “Дацантрейд” ХХК-ийн “Уртын хөндийн алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны үед сөрөг нөлөөлөлд хамгийн хүчтэй өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг нь газар, хөрс, агаар болон газрын доорхи ус, байгалийн бэлчээр, ургамалд үзүүлэх нөлөөллүүд голлох нөлөөлөлд хамаарч байна. Уулын үйлдвэрлэл явуулснаар тухайн нутгын биосферт нөлөөлж болохуйц процесс, тэдгээрийн үр дагаврыг дараах гол сөрөг нөлөөллийн хүснэгтгээр харуулсан болно.

*Гол сөрөг нөлөөлөл*

| Биосферийн элементүүд | Биосферийн элементүүдэд уулын үйлдвэрлэлийн үзүүлэх нөлөөлөл                                     | Гарч болзошгүй үр дагавар   |
|-----------------------|--|---|
| Хөрс                  | Овоолго, зам харилцаа, түр зуурын барилга байгууламж, тунгаагуур ба усан сан, шороон боомт барих | Газрын гадаргуугийн деформаци, хөрсний элэгдэл, угсралт, талбайн бүх төрлийн өөрчлөлт |
| Усан орчин            | Ус таталт, тунгаагуур, усан сангийн бохирдсон ус   | Усны нөөцийн горимын өөрчлөлт, урсгал ба гүний усны бохирдол                          |
| Агаарын орон зай      | Агаарын тоосжилт, хорт хийн тархалт  | Агаарын бохирдолт   |

## ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЗОРИЛГО

“Дацантрейд” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаварыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьдаг. Бид уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлж, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг бүрэн амжилттай хэрэгжүүлсээр ирсэн.

2022оны төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьсан.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2014 онд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгосон. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байсан болно.

Бид 2022 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хүрээнд дараахи гол зорилтуудыг тавьж ажилласан. Үүнд:

- Компанийн нийт ажилчдын байгаль орчны соёлыг өөрчлөх, экологийн мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг байгаль хамгаалах үйлст татан оролцуулах, компанийн байгаль орчны бодлого, хууль эрхзүйн дүрэм журмуудыг танилцуулах, нийт ажилчдыг хамарсан байгаль орчны сургалт, мэдлэг олгох зорилготой байгаль орчинд ээлтэй эко-уурхай болох зорилго тавьж ажилласан.
- Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг сайжруулж, түүнд нутгийн иргэдийг оролцоог хангах, дэмжих ажлыг үргэлжүүлэн хийнэ.
- Уурхайн усны менежментийг сайжруулж, хог хаягдлын хэмжээ, түүний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор шат дараатай арга хэмжээ хэрэгжүүлж, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахивар дахин боловсруулах зах зээлд нийлүүлэх хувь хэмжээг нэмэгдүүлнэ.
- Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц үр дагаврын тухайн нутгийн иргэдээс мэдээлэл өгөх явдлыг урамшуулж ажилласан.
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, нөхөн сэргээлтийн ажилд олон наст ургамлын үрийг ашигласан.
- Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг шат дараатай авсан.

### Эрх зүйн үндэслэл

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож авч хэрэгжүүлсэн.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 31.4 дэх заалт болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.6, 9.7 дахь заалт, 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний

дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн, 2020 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгасан ажлын хэсгийн дүгнэлтээс гарсан зөвлөмж зэргийг удирдлага болгов.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлс хийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг хангаж, явцад нь хяналт тавин ажилласан болно.

## ТАВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хүний нөөц, байгаль орчны удирдлагын бүтэц зохион байгуулалтын схемийн хамт дараахи чиглэлээр ажилласан. Үүнд:

1. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээний биелэлт
2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнасан байдал
3. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр хийгдсэн ажлууд.

### Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Энэхүү Уртын хөндийн алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны үед мөрдөх байгаль хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэгч нь “Дацантрейд” ХХК юм.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд “Байгаль орчныг хамгаалах тухай”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай”, “Усны тухай”, “Газрын тухай зэрэг хууль тогтоомжинд заасны дагуу төрийн захиргааны төв орон нутгийн байгууллагууд хяналт тавьж хэрэгжилтийг хангуулсан.

### Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийн болон үр дагаврын тархалтын хүрээний нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн, үзүүлэлтүүдийг тодорхойлсон байдал, дээж, сорьц авсан, хэмжилт хийсэн, түүнд дүн шинжилгээ хийсэн арга, байршил, хугацаа, шинжилгээ хийсэн давтамж, үр дүнг тайлагнасан, түүнийг хэрэгжүүлсэн арга хэлбэр, шаардагдсан хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан болно.

5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Гол ба болзошгүй сөрөг нөлөө   | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ  | Арга хэмжээний үр дүн  | Нэгжийн өртөг | Нийт зардал (сая.төг) | Хэрэгжүүлсэн хугацаа ба давтамж | Баримталсан стандарт, аргачлал                            |
|--|--|--|---------------|-----------------------|---------------------------------|---|
| <b>Агаар мандалд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</b> |  |  |               |                       |                                 |   |
| Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох  | Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо үйлчилгээг тогтмолжуулах,  | -Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо үйлчилгээг тогтмолжуулсан, утааны хэмжээ стандарт шаардлагын хэмжээнээс бага байсан.                                      | ҮА3-д         | ҮА3-д                 | 2-3 улирал                      | Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага MNS 4585 : 2007 |
|  | Уурхайн карьер, овоолгод ажиллаж байгаа ачих буулгах, тээвэрлэх машин техникийн кабин доторхи агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч байх; | - Машин техникийн кабин доторхи агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж хэвшсэн. | ҮА3-д         | ҮА3-д                 | 2022                            |   |
|  | Уурхайн үндсэн замд хайрга чулуу дэвсэх зэргээр технологийн замыг сайжруулж тоос босохоос хамгаалах  |  | 1.0           | 1.0                   |                                 |   |
|  | Тоосжилтоос сэргийлэхийн тулд уурхайн үндсэн талбайг тэмдэгжүүлнэ.   | - Уурхайн үндсэн талбайг тэмдэгжүүлсэн.  | 0.05          | 0.05                  |                                 | MNS 4585:98   |
| <b>Дүн</b>   |  |  |               | <b>1.45</b>           |                                 |   |

Усан орчинд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

|   |  |  |       |       |   |            |
|---|--|--|-------|-------|---|------------|
| Ашиглалтын улмаас газар доорхи усны түвшин буурах | Сав газартай ус ашиглах гэрээ байгуулж ажиллах   | - Сав газартай ус ашиглах гэрээ байгуулж ус ашиглалтын төлбөр/ 29 002 900 төгрөг/-ийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлсэн. | ҮАЗ-д | ҮАЗ-д |   | Хавсралт№1 |
|   | Унд ахуйн ус ашиглаж байгаа хэсгийг бохирдлоос сэргийлж цэвэрлэгээ арчилгааг тогтмол хийж, тэмдэгжүүлэх  | - Орон нутгийн малчид болон ажилчдын ундны усны худагийг орчны бохирдлоос хамгаалан засч сэлбэн сайжруулсан.           | 0.24  | 0.24  |    |            |
|   | Уурхайн дээд болон доод хэсэгт газар доорхи усны хяналтын мониторингийн 2 ширхэг цооног байгуулж, тохижуулах, жил бүрийн ОХШХ-өөр хэмжилт дээжлэлтийг хийлгэсэн. | - Төслийн талбайд  | ҮАЗ-д | ҮАЗ-д |   |            |
|   | Уртын булагийн эхийг хамгаалах, хаалт, хашилтыг засч сайжруулах.   | - Уртын булагийн эхийн эргэн тойрныг хамгаалж, засч сайжруулж байсан   | 0.4   | 0.4   |  |            |

|   |   |  |      |             |   |               |
|---|---|--|------|-------------|---|---------------|
|   | Ахуйн бохир ус болон ажилчдын 00-д био ялзмаг болгон задлах бодис ашиглаж саармагжуулах                               | - Тамир био ариутгагчийг хэрэглэснээр 00-ийн эвгүй үнэрийг дарж, бохир орчныг ариутгаж бактерийг саармагжуулсан.               | 0.5  | 0.5         |  | MNS 4586-98   |
| <b>Дүн</b>  |   |  |      | <b>1.14</b> |   |               |
| <b>Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэр төрхөнд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</b> |   |  |      |             |   |               |
| Хөрс эвдрэх, талхлагдах   | Уурхайн замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байршуулах, ухуулга сурталчилгаа хийх;  | -Уурхайн ойр орчимд болон, тосгон, төв замууд дээр шаардлагатай бүх тэмдэглээ хийж ухуулах самбар байршуулсан.                 | 0.25 | 0.25        |  | MNS 4597:2013 |
| ШТМ-ын агуулахыг байгуулах үед авах арга хэмжээ   | Шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх                             | -Зөвхөн зориулалтын талбайд шатах тослох материалтай харьцах бөгөөд хаягдал тос, материал ангилан хадгалах зориулалтын савтай. | 0.25 | 0.25        |  | MNS 5916:2008 |
|   | Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах; | -Сард 1 удаа операторуудад ухуулга таниулга хийж, шинээр ажилд орсон хүмүүст тухай бүр зааварчлага өгч байсан.                 | 0.5  | 0.5         | Ашиглалтын нийт хугацаанд, жил бүр  |               |
| <b>Дүн</b>  |   |  |      | <b>1.0</b>  |   |               |

| ГАЗРЫН ХЭВЛИЙД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ    |   |  |       |       |                        |                                   |
|---|---|--|-------|-------|------------------------|-----------------------------------|
|   | Олборлолтын улмаас эвдэрсэн газарт жил бүр нөхөн сэргээлтийн ажлыг зохих төлөвлөгөөний дагуу 90 хувиас дээш биелэлттэйгээр гүйцэтгэх, жил бүр нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох газруудаар дүгнүүлж ажиллах | -Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийж 11 сарын 22-ны өдөр орон нутагаас томилогдсон ажлын хэсэгт 91,2%-ийн үнэлгээтэйгээр хүлээлгэн өгсөн. | 0.45  | 0.95  | 2022 оны 2-4-р улиралд | MNS 4597:2013                     |
| Дүн   |   |  |       | 0.95  |                        |                                   |
| УРГАМАЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ |   |  |       |       |                        |                                   |
| Уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр ургамлан нөмрөг устах   | Уурхайн хаалтанд зориулж тухайн нутаг орны унаган ургамлын зүйлийн бүрдэлийг ашиглах  | -Орон нутагийн унаган ургамал болох ерхөг, согоовор, царгасыг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу тарьсан.  | ҮАЗ-д | ҮАЗ-д | 2022 оны 2-4-р улиралд | MNS 49119:2000                    |
| Дүн   |   |  |       | -     |                        |                                   |
| АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ     |   |  |       |       |                        |                                   |
| Уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр зэрлэг амьтад дайжих, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх                           | Уурхай ачиж тээвэрлэх үед тээврийн хэрэгслийн хурд тогтоох, осол гарч болзошгүй мал, амьтан өнгөрөн гардаг хэсгүүдэд тэмдэглэгээ байрлуулах   | -Төслийн үйл ажиллагаа явагдаж буй газар нутгийн орчимд тэмдэг байрлуулсан.  | ҮАЗ-д | ҮАЗ-д | 2022 оны 2-4-р улиралд | Амьтны аймгийн тухай хууль: 6.1.7 |
|   | Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, сургалтанд хамруулах, хяналт тавих   | -Нийт ажилчидыг сургалтанд хамруулсан.   | ҮАЗ-д | ҮАЗ-д | 2022                   |                                   |
| Дүн   |   |  |       | -     |                        |                                   |
| Нийт дүн  |   |  |       | 4.54  |                        |                                   |

## 5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

“Уртын хөндий”-ийн алтны шороон орд орчимд газрын гадарга, хөрс, гадаргын усан сүлжээ, ургамлан нөмрөгт үүсэх эвдрэлийг техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж, нөхөн сэргээх ажлын хэмжээ, холбогдох зардлыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, аргачлал, стандарт шаардлагын дагуу нарийвчлан тооцож гүйцэтгэсэн.

“Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт.” MNS 5914-2008; “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал” /MNS 5915-2008/; “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт /MNS 5916-2008/; “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5917-2008/; “Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага” /MNS 5918-2008/; Газрын тостой холбогдох үйл ажиллагааны үеийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх стандарт зэрэг орно.

2022 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн хувьд шимт хөрсийг хэлбэржүүлэн, угаан баяжуулах үед эвдэрсэн газрыг тэгшилж, шимт хөрсөөр хучих техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн.

Техникийн нөхөн сэргээлтийг Бульдозер CAT D5 - 1 ш, Бульдозер SD-23 - 1 ш тусламжтайгаар 2021-2022 онд хөндөгдсөн болон эвдрэлд орсон 1,4 га талбайд хийсэн ба нөхөн сэргээлтийн ажлын 50-60%-г дотоод овоолгоор, 30-40%-г гадаад овоолгоор гүйцэтгэсэн. Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 09-р сарын 20-с 10-р сарын 10 хүртэл 20 хоногийн хугацаанд стандарт норм, дүрэм журмын дагуу хийж гүйцэтгэн хүлээлгэж өгсөн.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг Бульдозер CAT D5 - 1 ш, , Эксковатор –CAT-320 - 1ш, ОВ-10 үрлэгч, автосамосвалийн тусламжтайгаар 5хүний бүрэлдхүүнтэй мэргэжлийн 6-рсарын 18-с 7-р сарын 8 хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн. Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийхдээ эхний ээлжинд тэгшилж бэлэн болгосон талбайд тусгайлан хадгалсан шимт хөрсийг 15-20см, заримдаа 30см хүртэл зузаантайгаар жигд тарааж өгсөн. Дараагийн шатанд пад тракторт угсарч бэлэн болгосон үрлэгчинд бэлдсэн тухайн орон нутагт тарьж ургуулахад тохиромжтой нь тогтоогдсон олон наст ургамал болох царгас/Омская-192/, согооврын холимогийг 2-4см гүнд суухаар, 30см өргөн мөрөөр, 1га-д 60-70кг орцтой нормоор тарьж суулгалт хийсний дараа булдаж өгсөн. 2022 онд техникийн нөхөн сэргээлт хийж бэлдсэн 5,4 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн. Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн зураглалыг 10-р сарын 20-нд “Оюу Сервей” ХХК-р гүйцэтгүүлсэн болно. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон нөхөн сэргээлтийн ажлыг 2022. 11.122-ны өдөр сум, орон нутаг, аймгийн зохих мэргэжлийн байгууллагуудаас томилогдсон комисс хүлээн авсан болно. Үнд:



1. 2022 оны БОМТ-ий биелэлт- дундаж 91,2%

Биологийн нөхөн сэргээлт: 5,4 га

Шимт хөрс: 1,3га

Техникийн нөхөн сэргээлт:1,4 га

Нөхөн сэргээлтийн чиглэлээр хийх арга хэмжээний төлөвлөгөө

| №  | Зардлын утга  | Хэмжих нэгж        | Ажлын хэмжээ  | Ашиглагдах техник, тайлбар | Нэгж өртөг мян.төг | Нийт зардал, сая.төг | Баримтлах стандарт, аргачлал  |
|--|---|--------------------|---|----------------------------|--------------------|----------------------|---|
| Техникийн нөхөн сэргээлт / 1,4 га/ - Бэлтгэл ажлын зардал: |   |                    |   |                            |                    |                      |   |
| 1  | Нөхөн сэргээлтийн ажлын хөрөнгө оруулалтын зардал     | Сая.төг            | Шаардлагатай хөрөнгө худалдан авахад зарцуулах зардал |                            |                    |                      |   |
| 2  | Нөхөн сэргээлтийн ажлын төсөл боловсруулах зардал     | Сая.төг            | Нөхөн сэргээлтийн зардлын төсөвт өртгийн 3-5%         |                            |                    | 0.5                  |   |
| А. Нөхөн сэргээлтийн бэлтгэл ажлын дүн                     |   |                    | 1+2   |                            | <b>0.5</b>         |                      |   |
| Техникийн нөхөн сэргээлтийн ажил                           |   |                    |   |                            |                    |                      |   |
| 4  | Шимт хөрсний үе давхаргын хуулах, ачих, хадгалах      | Мян.м <sup>3</sup> | 5.4   | Бульдозер, Экскаватор      | 0.4                | 2.16                 | “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008”, 2010.05.17 А-132/112 |
| 5  | Хөрс тээвэрлэх  | Мян.м <sup>3</sup> | 5.4   | Бульдозер, Экскаватор      | 0.4                | 2.16                 |   |
| 6  | Уурхайн малталтыг дүүргэж, тэгшлэх                    | Мян.м <sup>3</sup> | 10.6  | Бульдозер, Экскаватор      | 0.4                | 4.24                 |   |
| 7  | Овоолгын талбайг хэлбэржүүлэн тэгшлэх, нягтаршуулах   | Мян.м <sup>3</sup> | 13.2  | Бульдозер, Экскаватор      | 0.8                | 10.56                |   |
| 8  | Шимт хөрсөөр талбайг хучих                            | Мян.м <sup>3</sup> | 13.2  | Бульдозер, Экскаватор      | 0.4                | 5.28                 |   |
| 9  | Тэгшилсэн талбай дээр дэвссэн хөрсний үеийг тэгшлэх   | Мян.м <sup>3</sup> | 6.6   | Экскаватор                 | 0.8                | 5.28                 |   |
| 10   | Овоолгын хажууг хэвгийжүүлэх, дэвсгэжүүлэх            | Мян.м <sup>3</sup> | 0,28  | Экскаватор                 | 0.8                | 0.112                |   |
| 11   | Туслах байгууламж байгуулахад үүссэн овоолгыг тэгшлэх | Мян.м <sup>3</sup> | 0,4   | Бульдозер, Экскаватор      | 0.8                | 0.32                 |   |
| 12   | Ургамалжуулахад бэлтгэн хөрсийг нягтаршуулах          | м <sup>2</sup>     | 4.0   | Экскаватор                 | 0.4                | 1.6                  |   |
| 13   | Хөрс боловсруулах, сайжруулах                         | Мян.м <sup>3</sup> | 4.0   |                            | 0.2                | 0.8                  |   |

|   |                                      |                    |                    |  |              |              |   |  |
|---|--------------------------------------|--------------------|--------------------|--|--------------|--------------|---|--|
| 14  | Шимт хөрсийг хадгалах, хамгаалах     | Мян.м <sup>3</sup> | 4,0                |  | 0.2          | 0.8          |   |  |
| Техникийн нөхөн сэргээлтийн ажлын дүн               |                                      | Сая.төг            | $\Sigma(4-14)$     |  | <b>33.3</b>  |              |   |  |
| Биологийн нөхөн сэргээлт /5,4 га/ -ийн ажлын зардал |                                      |                    |                    |  |              |              |   |  |
| 15  | Бүрхэвч ургамал тарих                | га                 | 5.5                |  | 480.0        | 2.6          | Эвдэрсэн газрыг ургамалжуулах MNS 4918:2000, “Мод сөөгний тарьц, Техникийн шаардлага: MNS 6140-2010 4х” |  |
| 16  | Олон наст ургамалын үр тарьж суулгах | га                 | 5.5                |  | 480.0        | 2.6          |   |  |
| 17  | Ургамлын үр худалдан авах            | кг                 | 398                |  | 1.6          | 8.16         |   |  |
| 18  | Усалгаа, арчилгаа, тордолт хийх      | га                 | 5.5                |  | 65.6         | 0.36         |   |  |
| Биологийн нөхөн сэргээлтийн ажлын дүн               |                                      | Сая.төг            | $\Sigma(15-18)$    |  | <b>13.72</b> |              |   |  |
| НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН            |                                      | Сая.төг            | $\Sigma_{кс}A+B+C$ |  |              | <b>47.52</b> |   |  |

### 5.3 Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний талаар

Аливаа уул уурхайн хөгжлийн нөлөөллийг зохистой бууруулахын тулд нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно.

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт

| №           | ДХ зорилт  | Хамгааллын арга хэмжээ                             | Арга хэмжээний цар, хэмжээ                           | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа давтамж |
|-------------|--|--|--|-------------|------------|----------------------|-----------------------------|
| 1           | Биологийн олон янз байдлыг сайжруулах, менежментийн арга хэмжээг тодорхойлох             | Ангирт багийн Энгэртийн булагийг хашиж хамгаалсан. | Хэрлэн Голын сав газрын Усны гэрээнд заагдсаны дагуу | га          | 1          | 5 000.0              | 2022 онд                    |
| 2           | МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод төслийн хүрээнд 200ш улиас, хайлаас тарьсан. | Багийн төв   |  | ш           | 200        | 1 660.0              | 2022 онд                    |
| Нийт зардал |  |  |  |             |            | 6 660.0              |                             |



#### 5.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөөний талаар

Тусгай зөвшөөрлийн эзэмшлийн бүс нутаг нь тал хээрийн бүсэд хамаарах бөгөөд ойролцоо томоохон хот суурин газар байхгүй. Харин ордын урд захад Норовлин сумын 1 дүгээр багийн хуучин малын эмчилгээ тэжээлийн цэг байрладаг. Тус ордод хамгийн ойрхон хүн ам төвлөрсөн газар нь улирлын чанартай ажилладаг Салхитын алтны уурхай 10 км зайд, Тохойбулагийн алтны уурхай 11 км зайд, Норовлин сумын төв 50 км зайд байрладаг. Норовлин сумын хүн ам нь голчлон хувиараа мал аж ахуй эрхэлдэг. Зам харилцааны хувьд Хэнтий, Дорнод аймгийн хойд, урд сумууд болон Хэнтий аймаг, Бэрхийн уурхай, Норовлин сумуудыг холбосон сайжруулсан шороон зам нь ордын баруун талаар 25 км зайд өнгөрдөг. Иймд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал гараагүй болно. Өөрөөр хэлбэл ашиглалтын талбай болон бусад үйл ажиллагаа явуулах талбайнуудад ямар нэгэн айлын өвөлжөө, хаваржаа байхгүй тул 2022 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ авагдаагүй.

#### 5.5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний тухай

Ашиглалтын талбайн ойр орчимд болон олборлолтын явцад ямар нэгэн түүх, археологи олдвор, дурсгалт зүйлс байх ул мөр тогтоогдоогүй.

#### 5.3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт:

| Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл  | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ  | Арга хэмжээний цар, хэмжээ  | Тоо хэмжээ | Нэгжийн зардал сая.төг | Нийт зардал сая.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|--|---|---|------------|------------------------|---------------------|--------------------------------|---------------------------------|
| Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж, олборлолтын үйл ажиллагаа доголдох, зогсох | Ажилчин нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах  | Нийт ажилчдыг ЭАХХ-ын стандартад нийцсэн хувцас, хамгаалах хэрэгслээр хангасан.     | 25         |                        | ХАБЭА-ын зардалаар  | Жил бүр                        | ХАБЭА                           |
|  | Ажилчин нэг бүрт ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалсан хор тайлах зорилгоор өдөр бүр нормын сүү, цагаан идээгээр хангах | Орон нутгийн малчидтай сүү, цагаан идээний гэрээ байгуулж ажилчдад нийлүүлж байсан. |            | 25                     |                     | ХАБЭА-ын зардалаар             | Жил бүр                         |

#### 5.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Бид 2022 онд хог хаягдлын менежментийг сайжруулах зарчмын хүрээнд төсөлд тусгагдсан хэд хэдэн ажлын хэрэгжилтийг хангаж ажилласан. Үүнд:

- Анхан шатны эх үүсвэр дээр хог хаягдлыг багасгах
- Хаягдал бүтээгдэхүүний дахин ашиглах
- Хаягдал бүтээгдэхүүнийг дахин боловсруулах зах зээлд нийлүүлэх
- Уурхайн үйл ажиллагаанаас гарч буй бүхий л төрлийн дахин ашиглагдах боломжтой хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж зориулалтын сав, тусгайлан бэлдсэн талбайд цуглуулж хураах
- Ангилан ялгаж цуглуулсан хог хаягдлыг хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд халгүйгээр цуглуулах, уурхайн тосгоноос зайлуулах зорилгоор хог хаягдлыг нэгдсэн цэгт эмх цэгцтэй төвлөрүүлэх
- Хог хаягдалтай холбоотой журмуудыг уурхайн нийт ажилчдад таниулах, хог хаягдлыг ангилан ялгах дадал соёлыг хэвшүүлэх сургалтыг тогтмол явуулах
- Ажлын байрны үзлэг шалгалтыг тогтмол хийж, журмуудын хэрэгжилтийг хангаж байгаа байдалд хяналт тавих
- Уурхайн хэмжээнд дахин ашиглагдах хог хаягдлыг ангилан ялгаж, нутгийн иргэдэд тогтмол тогтсон журмын дагуу олгох
- Хоёрдогч түүхий эд дахин боловсруулдаг, бэлтгэдэг, цуглуулдаг, тээвэрлэдэг, зах зээлд нийлүүлдэг иргэд, байгууллага, үйлдвэрүүдэд худалдан борлуулах, нийлүүлэх замаар уурхайн тосгоноос зайлуулах ажлыг гүйцэтгэх
- Хамгийн сүүлд шатааж болох аюулгүй хог хаягдлыг булаах байдлаар устгах

Тус төслийн хүрээнд дараах журмуудыг дагаж мөрдсөн. Үүнд:

- Уурхайн тосгоны хог хаягдлыг хаях, хадгалах, хянах журам
- Уурхайн засварын газрын хог хаягдлын журам
- Хог хаягдал ачиж цуглуулах, тээвэрлэх болон устгах журам
- Уурхайн тосгоноос дахин ашиглагдах хог хаягдлыг зайлуулах журам

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

| №  | Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө  | Урьдчилан сэргийлж, хамгаалсан арга хэмжээ   | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг | Нийт зардал (сая.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал   |
|----|---|--|----------------------------|---------------|-----------------------|--------------------------------|--|
| 1. | Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын нөлөөгөөр хөрс, ус, агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх | Засварын хатуу, шингэн хог хаягдлыг битүү зориулалтын савд ялган цуглуулж орон нутгийн нэгдсэн цэг рүү ачуулсан. | 2022                       | 0.15          | 0.65                  | Нэг удаа                       | Хог хаягдалын үндэсний хөтөлбөр, Хог хаягдлын тухай хуулийн 11, 14-р зүйл, |
|    |   | Ахуйн хэрэгцээнээс гарах хог хаягдлыг ялгаж, орон нутгийн нэгдсэн цэг рүү ачуулсан.                              | 2022                       | 0.14          | 0.64                  | Нэг удаа                       |  |
|    |   | Уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа нүхэн жорлонг сайжруулж, сар бүр ариутгаж халдваргүйжүүлж байх         | 2022                       | 0.95          | 1.95                  | 7 хоногт 1-2 удаа              |  |
|    |   | Дүн  |                            |               | 3.240                 |                                |  |

5.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн биелэлт (охшх)

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтэд нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлсон үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийсэн шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийсэн хугацаа ба давтамжийг тодорхойлон оруулсан. Мөн уг ажлын хэмжээнд хэмжих нэгж, нэгжийн үнэ, нийт зарцуулсан зардал, баримтлах стандарт, аргазүй, аргачлалыг тусгасан. Тус компани нь Баян уулын уурхайн ус, хөрс, агаарын шинжилгээг Хэнтий аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний албатай 1 жилийн хугацаатай хийсэн гэрээний дагуу 2022 оны 5-р сарын дундуур болон 9-р сарын дундуур нийт 2 удаа хийлгэн үр дүнг тайланд тусгаж өгсөн бөгөөд шинжилгээний үр дүнгээс үзэхэд шинжилгээ стандарт хэвийн хэмжээнд байгаа болно. Шинжилгээний үр дүнг хавсралтаар хүргүүлэв.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

| №                                      | Хяналт шинжилгээ хийсэн үзүүлэлтүүд   | Байршил   | Хугацаа ба давтамж  | Хяналт шинжилгээний ажлын үр дүн, харьцуулалт   | Нэгжийн өртөг, Сая\төг | Нийт зардал, сая, Төг/жил | Баримтлах стандарт ба арга, аргачлал  | Дээд доод Хязгаар   |
|--|---|---|---|---|------------------------|---------------------------|---|---|
| <b>АГААРЫН ЧАНАР</b>                   |   |   |   |   |                        |                           |   |   |
| 1                                      | Агаар дахь тоосжилтын хяналт:   | - Элс олборлох карьерын орчим<br>- Ажилчдын тосгон<br>-Замын хажууд           | Тоосжилтыг PM <sub>2.5</sub> , PM <sub>10</sub> гэсэн 2 үзүүлэлтээр жилд 2 удаа авсан | TSP, SO <sub>x</sub> , NO <sub>x</sub> , CO <sub>x</sub>  | 0.35                   | 0.72                      | MNS 4585:1998<br>MNS:3384:1982<br>MNS:4048:1988<br>MNS 4048:1988<br>MNS 5918:2009                 | ЗДХ   |
| <b>Дүн</b>                             |   |   |   |   |                        | <b>0.72</b>               |   |   |
| <b>ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХИ УС</b> |   |   |   |   |                        |                           |   |   |
| 1                                      | усны түвшин, ундарга зэрэг үзүүлэлтүүдэд хэмжилт хийх, сорьц дээж авч, шинжилгээ хийх зэргээр тогтмол хяналт тавих; | Унданд хэрэглэгддэг худаг болон уурхайн карьераас доор байрлах горхины уснаас | 5 ба 9-р сард нийт 2удаа авсан  | Горхины худагны уснаас авахдаа байнга авдаг тогтмол цэгээс дээж авсан бөгөөд стандарт хэмжээний үзүүлэлттэй байсан.   | 0.23                   | 0.46                      | MNS 3934:1986 - ундны болон үйлдвэрлэлийн хэрэгцээт ус MNS (ISO) 5667-5:2001- усны чанар-дээжлэлт | Усны бүх төрлийн шинжилгээгээр стандарт хэвийн хэмжээнд гарсан болно. |
| 2                                      | Ph, TDS, нийт хатуулаг, үнэр, өнгө, жигнэгдэх бодис.  | карьерийн уснаас эсвэл Угаах төхөөрөмжийн орчимд                              | 5 ба 9-р сард нийт 2удаа авсан  | Уурхайн ашиглаж байгаа карьерийн ус, угаах төхөөрөмжөөс гарч буй хаягдлын нуур зэрэг хөдөлгөөнт цэгүүдээс дээж авсан. | 0.23                   | 0.46                      | MNS 3934:1986<br>MNS (ISO) 5667-5:2001- усны чанар-дээжлэлт                                       | Усны бүх төрлийн шинжилгээгээр стандарт хэвийн хэмжээнд гарсан болно. |
| <b>Дүн</b>                             |   |   |   |   |                        | <b>0.9</b>                |   |   |
| <b>3. ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>               |   |   |   |   |                        |                           |   |   |
| 1                                      | Хөрсний бохирдол, ялзмагийн агууламж, рh,   | - Угаах төхөөрөмжийн орчинд<br>- шатахуунаар цэнэглэх талбайн орчимд          | 5 ба 9-р сард нийт 2удаа авсан /2 дээж/   | PO <sub>4</sub> 98,6-329,5<br>SO <sub>4</sub> -45-164.5<br>NH <sub>4</sub> -6,8-189,4<br>NO <sub>3</sub> -17,4-115,3  | 0.2                    | 0.4                       |   | ЗДХ   |

|  |  |   |                         |  |     |              |                   |     |
|--|--|---|-------------------------|--|-----|--------------|-------------------|-----|
|  | давсжилт, чийгшил, NO <sub>3</sub> -N, P <sub>2</sub> O <sub>5</sub> , K <sub>2</sub> O, Ph, нийт азот, нийт фосфор, 1.0 см <sup>3</sup> дэх бактер, эмгэг төрүүлэгч нян | - нөлөөлөлд өртөөгүй талбай   |                         | РН-7,01-8,4<br>Чийг-2,51-43,6<br>Ялзмаг-4,12 -7,65                               |     |              |                   |     |
| 2                                      | Нефть, нефтийн бүтээгдэхүүн, нүүрсустөрөгчид, хар тугалга (Pb) г.м   | -Угаах төхөөрөмжийн орчинд<br>- шатахуунаар цэнэглэх талбайн орчимд<br>- Хогийн цэг орчим | Жилд 1 удаа<br>/3 дээж/ | Cr-0.01-0.05<br>Pb-0.01-0.435<br>Cd-0.003-0.015<br>Ni-0.02-0.559<br>Zn-0.004-5.0 | 0.2 | 0.4          | MNS5850 :<br>2008 | ЗДХ |
| Дүн                                    |  |   |                         |  |     | 0.85         |                   |     |
| <b>4. ДУУ ЧИМЭЭ БА ДОРГИО ЧИЧИРГЭЭ</b> |  |   |                         |  |     |              |                   |     |
|  | Гадаад орчны дуу чимээ   | - Нийт талбайд<br>- Ил уурхайн орчимд   | 9-р сард                | Дундаж ДБА -55<br>Дундаж ДБА -60   | YA3 | YA3          | MNS5850 :<br>2016 |     |
|  | Ажлын байрны дуу чимээ   | - Ил уурхайн орчимд<br>- Элс угаах төхөөрөмжийн орчинд                                    | 9-р сард                | Дундаж ДБА -59<br>Дундаж ДБА -60   | YA3 | YA3          | MNS5850 :<br>2016 |     |
| <b>Нийт дүн</b>                        |  |   |                         |  |     | <b>2.465</b> |                   |     |



### 5.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

“Дацантрейд” ХХК нь “Уртын хөндий”-н алтны шороон ордод 2022 онд БОМТөлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхдээ дараах удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу ажилласан болно.

#### Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

| № | Хэрэгжүүлсэн арга хэмжээ                                     | Зардал, сая.төг | Хариуцсан эзэн, үр дүн  | Баримтлах стандарт, аргачлал |
|---|--|-----------------|---|------------------------------|
| 1 | БОМТөлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан боловсруулалт      | -               | Байгаль орчны ажилтан БОМТ боловсруулж холбогдох шатны төрийн байгууллагаар батлуулсан. | ISO 14001                    |
| 2 | Нийт ажиллагсад байгаль орчны талаарх сургалтыг өгч хэвшсэн. | ҮАЗ             | уурхайд 6 ба 9-р сард 2удаа сургалт, таниулга хийсэн.                                   |                              |

### 5.10. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнаж, хэлэлцүүлэх хуваарь:

Уртын хөндийн алтны шороон ордыг ашиглах явцад байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс зайлс хийх, бууруулах, нөхөн сэргээх арилгах, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажилласан.

Бид 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх мэдээллийг талуудад дараах хуваарын дагуу тайлагнасан.

| Тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд | Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр          | Мэдээллийн агуулга   | Хугацаа      | Хэлэлцүүлгээр санал авсан чиглэл        | Зохион байгуулсан газар |
|--------------------------------------|--|--|--------------|---|-------------------------|
| Байгаль орчин, ногоон хөгжлийн яам   | Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт | Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна | Жилийн эцэст | Цаашид төлөвлөгөөнд шинээр тусгах зүйлс | Улаанбаатар хот         |

|  |   |   |                         |   |                 |
|--|---|---|-------------------------|---|-----------------|
| Мэргэжлийн хяналтын ерөнхий газар                    | Тайлангийн товч хураангуй, албан бичгийн хамт | Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр товч илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зураг, шинжилгээ, судалгааны үр дүнгээр баталгаажсан байна | Жилийн эцэст            | Цаашид төлөвлөгөөнд шинээр тусгах зүйлс | Улаанбаатар хот |
| Хэнтий аймгийн байгаль орчны газар                   | Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт        | Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна                                      | Жилийн эцэст            | Цаашид анхаарах зүйлс, Хамтран ажиллах  | Хэнтий аймаг    |
| Норовлин сумын Засаг дарга                           | Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт        | Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна                                      | Хагас жил, жилийн эцэст | Хамтран ажиллах                         | Норовлин сум    |
| Норовлин сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч | Тайлангийн товч хураангуй                     | Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр товч илэрхийлэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зураг, шинжилгээ, судалгааны үр дүнгээр баталгаажсан байна | Хагас жил, жилийн эцэст | Хамтран ажиллах                         | Норовлин сум    |

## 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үед олон нийтийн оролцоог хангасан нь

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх шатанд олон нийтийн оролцоог тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог хууль тогтоомжид заасан хүрээнд аль болох өргөн хангах, тэдэнд ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт болсон.

Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран төсөл хэрэгжих орчны байгаль орчин, нийгэм-эдийн засаг, болзошгүй нөлөөллийн бүс дэх оршин суугчдын эрүүл мэндийн байдлын талаарх мэдээлэл, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төслийн техникийн болон эдийн засгийн гол үзүүлэлтүүд, төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, нөлөөллийн цар хүрээ, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээний талаар болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар үнэн зөв, бодит мэдээлэл бүхий илтгэл, танилцуулах хуудас, материалыг бэлтгэн аймаг, сум орон нутгийн ИХ, ЗДТГ, мэргэжлийн хяналтын газар байгаль орчны

газарт хүргүүлсэн бөгөөд багийн иргэдийн хуралд танилцуулсан. Мөн төлөвлөгөөний эх хувийг тэдэнд танилцах боломжоор нь бүрэн хангаж ажилласан.

## 7.0 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал

**Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал**

| №   | Арга хэмжээ   | Зардал, мян.төг |
|---|---|-----------------|
| 1   | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө  | 4 540.0         |
| 2   | Нөхөн сэргээлт хийх, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө   | 47 520.0        |
| 3   | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө   | 6 660.0         |
| 4   | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө  | -               |
| 5   | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө   | -               |
| 6   | Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө  | -               |
| 7   | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө   | 3 240.0         |
| 8   | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө                           | -               |
| 9   | Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь | -               |
| 10  | Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр  | 2 465.0         |
| <b>2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал</b> |   | <b>64 425.0</b> |

“Дацан трейд” ХХК-ийн “Уртын хөндийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл” төслийн үйл ажиллагаандаа 2022 онд хэрэгжүүлэн ажилласан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал **64 425.0 мян.төг** болж байна.

## ДҮГНЭЛТ

Хэнтий аймгийн Норовлин сумын нутагт орших ашигт малтмал ашиглах MV-015599 тоот тусгай зөвшөөрөл бүхий Уртын хөндийн талбайд 2022 онд батлагдсан БОМТ-ий дагуу алтны шороон ордын олборлолт хийсэн үр дүнгийн биелэлтийн тайланг боловсруулав.

Тус компани нь 2022 онд MV-015599 тоот тусгай зөвшөөрөл бүхий Уртын хөндийн алтны шороон ордын 3-В,4-В блокын хагаст олборлолтын үйл ажиллагаа явуулж нийт 129 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 32,0мян.м<sup>3</sup> элс угааж, 13,5 кг/шлихээр/ алт олборлож улсын эрдэнэсийн санд тушаасан. Мөн MV-015597, MV-015599 тоот тусгай зөвшөөрөл бүхий Баян уул талбайн 1,4 га талбайд техникийн нөхөн сэргээлт, Баян уул-3 талбайд 5,4га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэлээ.

Мөн Баян уулын уурхайн 2022 оны олборлолтын болон нөхөн сэргээлтийн маркшейдерийн ажлыг “Оюу Сервей”ХХК-р, ус, хөрс, агаарын шинжилгээг Хэнтий аймгийн ус цаг уур орчны албаар 2 удаа, МХГ-ын Лабораториор тус тус гэрээний дагуу хийлгүүлсэн. 2022 оны Байгаль орчин менежментийн төлөвлөгөөний биелэлт болон техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлтийн ажлыг Хэнтий аймгийн засаг даргын 2014 оны А/493 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсэг 2022 оны 11 -р сарын 22- нд хангалттай сайн /91,2%/ гэсэн үнэлгээтэйгээр хүлээн авсан болно.

”Дацан трейд” ХХК нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм журам, стандарт болон энэхүү тайланд тусгагдсан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн ажилласан.